



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 460

Улаанбаатар хот

┌ “Хаан даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн хөрөнгийн
хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хаан даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч Г.Энхбилэгээс 700,000,000.0 /долоон зуун сая/ төгрөг, иргэн Г.Лхагва-Очироос 150,000,000.0 /нэг зуун тавин сая/ төгрөг, нийт 850,000,000.0 /найман зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Эцсийн үлдэгдэл	
1	Ж.Баярсайхан	1,250,000,000.0	0.0	1,250,000,000.0	41.0
2	Г.Энхбилэг	750,000,000.0	700,000,000.0	1,450,000,000.0	47.5
3	А.Мэндбаяр	100,000,000.0	0.0	100,000,000.0	3.3
4	Ч.Чимидсүрэн	100,000,000.0	0.0	100,000,000.0	3.3
5	Г.Лхагва-Очир	0.0	150,000,000.0	150,000,000.0	4.9
	Дүн	2,200,000,000.0	850,000,000.0	3,050,000,000.0	100.0

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Хаан даатгал” ХХК /Б.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

330803